



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/НСЭ

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 33,600,000 (гучин гурван сая зургаан зуун мянга) төгрөгийн өртөгтэй Уаз-Фургон маркийн автомашиныг Богд сумын Цагдаагийн тасагт, 19,500,000 (арван есөн сая таван зуун мянга) төгрөгийн өртөгтэй Ниссан караван маркийн автомашиныг Арвайхээр сумын 11 дүгээр тусгай цэцэрлэгт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, урлагийн газрын 33,000,000 (гучин гурван сая) төгрөгийн өртөгтэй Уаз-Фургон маркийн автомашины үнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 13/03 тогтоолын 2 дугаар хавсралтын 8-т тусгагдсан “Төрийн байгууллагуудын автомашины шинэчлэл, засвар, үйлчилгээ”-ний зардлаас, 19,000,000 (арван есөн сая) төгрөгийн өртөгтэй Ниссан караван маркийн автомашины үнийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас нийт 52,000,000 (тавин хоёр сая) төгрөгөөр санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т даалгасугай.

3.Аймгийн Боловсрол, соёл урлагийн газарт төвлөрсөн 52,000,000 (тавин хоёр сая) төгрөгөөс 3000,000 (гурван сая) төгрөгийг автомашины засварын зардалд, бага оврын автобус худалдаж авах 49,000,000 (дөчин есөн сая) төгрөгийг зарцуулах эрхийг Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т шилжүүлсүгэй.

4.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011101007